

Говь Алтай аймгийн Аудитын газар



Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу
хийсэн нийцлийн аудитын тайлан

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
ҮАГ-НАГ-/2016/05-НА/



УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ТҮҮНЭЭС ОРУУЛАХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ГҮЙЦЭТГЭЛ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймгийн Аудитын
газрын
III баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Ахлах аудитор
Д.Цэрэнханд
Утас: 99147999

Аудитор:
Г.Цэцэгмаа
Утас: 99489399

Шинжээч:
Ц.Сайханжаргал
Утас: 88665099

2016 оны 09 дүгээр сар

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70483413, 70484055 дугаарын
утас, 70484030 дугаарын
факсаар харилцана уу.

Хаяг:
Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум
Баянхайрхан баг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....

НЭГ: АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГА НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН БҮРЭН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

ХОЁР: ОЙ, УРГАМАЛ, ХҮН АМЫН УНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАСАН УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ОРЛОГЫГ ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

ГУРАВ: ОЙ, УС, УРГАМАЛ, АМЬТНЫГ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД 67.3 САЯ ТӨГРӨГИЙГ ХУУЛИЙН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

ДӨРӨВ: ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ГИДЦГ	Говийн их дархан цаазат газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өсчин аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СС	Сангийн сайд
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгийн хорооны 2016 оны 1 дүгээр сарын 01 тоот тогтоол, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Говь-Алтай аймгийн Аудитын газрын 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт:

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ.

1. Аймгийн ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх
4. Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ: Аудитад БОАЖЯ, түүний харьяа байгууллагууд, аймаг, сумдын ИТХ, бүх шатны Засаг дарга түүний харьяа байгууллага, бүх шатны татварын байгууллага, холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдийг хамруулан тэдгээрийн 2015 оны ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлан газар дээр нь үзэж ярилцлага хийж аудитыг гүйцэтгэлээ.

Тодруулга: Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд хийх энэ аудитад газар, түүний хэвлий дэх нөөц хамрагдаагүй болно. 2015 онд аудит хийсэн болно.

Үүнд:

- Аймгийн Засаг даргын БОАЖЯ-ын яамны сайдтай хийсэн гэрээ, биелэлтийг дүгнэсэн ажлын хэсгийн тайлан
- Харилцах дансны хуулгууд
- Орлогын төлөвлөлтийн баримт материал

- Статистик мэдээлэлүүд, судалгаа шинжилгээний баримтууд
- Байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл олгосон байгууллагуудын жагсаалт
- Ойн мэргэжлийн байгууллагын эрх олгосон байгууллагын жагсаалт
- Санхүүжилт хийгдсэн баримтууд, зарцуулалтын баримт материалууд
- Хяналт мониторингийн ажлын баримтууд
- Байгалт орчныг хамгаалах түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө
- Удирдлагын тайлбар
- Хэрэглэгч, иргэдийн санал
- Бусад шаардлагатай санхүүгийн баримтууд

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, зорилго

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Үндсэн мэдээлэл:

1-р зорилтын хүрээнд: аймгийн Засаг дарга, аймгийн ИТХ байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан хэрэгжилтийг хангуулсан байдал

Аймгийн БОГ нь Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр 9 зорилтын хүрээнд 85 ажлыг хийхээр дэвшүүлсэн, удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 4 зорилтын хүрээнд 20 ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөгөөний биелэлтийг хянаж үзвэл: 2015 онд 105 ажил хийхээр төлөвлөж, 97 ажил биелэгдэж, 6 ажил хэрэгжих шатандаа, 2 ажил хийгдээгүй тасарсан байна.

2-р зорилтын хүрээнд: Нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт зарцуулалтын талаар БОГ-аас мэдээлэл авахад дараах байдалтай байна.

- Ус ашиглалтын мэдээлэл: Тус аймагт 2015 онд ус ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа 109 аж ахуй нэгж байгууллага байна. Үүнээс гадаргын ус ашигладаг-19, сумын төвийн худгаас зөөвөрлөн ашигладаг-4, бэлчээрийн худгаас ашигладаг-2 байгаагийн дээр 23 компаний эзэмшилд 28 худаг ашиглагдаж байгаагийн 16 худаг тоолууртай, 12 худаг тоолуургүй, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-аас шугам хоолойгоор татан авч ашигладаг-59 ус ашиглагчаас 3 аж ахуй нэгж тоолуургүй байна. 2015 онд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашиглах усны төлбөрийг 192.1 сая төгрөгөөр тогтоож төсвийн төсөлд тусгасан байна.
- Байгалийн ургамал, ан амьтны талаарх мэдээлэл: Ан агнуур хийх зөвшөөрлийг тухайн сумаас харьяа яам руу хүсэлт явуулснаар олгогддог байна. Аймгийн БОГ дээр ан амьтан, ургамлын талаарх статистик мэдээлэл байсангүй.
- Ойн нөөцийн талаарх мэдээлэл: Тайлант онд ойн нөөц ашигласан газар байхгүй, төлбөрийг оруулахаар төлөвлөөгүй байна.

Мөн татварын хэлтсээс ирүүлсэн мэдээллээр 2015 онд нийт 185.8 сая төгрөгийн орлого орохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 132.1 сая төгрөгийн орлого орсон ба орлогын төлөвлөгөөний биелэлт 71.8%-тай буюу 28.9%-иар тасарсан байна.

Үүнийг задалбал:

- ТТББА-ын төлбөрөөс 41.7 сая төгрөг орохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 36.3 сая төгрөг орсон.
- Агнуурын нөөц ашигласны төлбөрөөс Алтай сумаас 20.8 сая төгрөгийн төлбөр орохоор төлөвлөснөө гүйцэтгэлээр 100% орсон байна.
- Харин байгалийн ургамал ашигласны төлбөрөөс 5.0 сая төгрөг орохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4.1 сая мянган төгрөг орсон байна.
- Ус рашаан ашигласны төлбөрөөс 118.1 сая төгрөг орохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 70.9 сая төгрөг орсон байна.

3-р зорилтын хүрээнд: Аймгийн ИТХ-ийн тогтоолоор 55.6 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр /булгийн эх хамгаалах, мод үржүүлгийн талбай өргөжүүлэх, ойн зурвас байгуулах, мазаалай баавгайн биотехнологийн үйл ажиллагаанд/ зарцуулахаар батлагджээ.

Дээрх төлөвлөсөн ажлууд 100% хийгдсэн ба 6.0 сая төгрөгийг Есөнбулаг, Цээл, Тонхил сумдад булаг шандны эх хамгаалах ажилд, 6.0 сая төгрөгийг Цээл, Дарив сумдад усан сан бүхий хамгаалалтын бүс тогтоох тэмдэгжүүлэх, загон татаж дэглэм мөрдүүлэх ажилд, 10.0 сая төгрөгийг Бигэр, Шарга сум, Дэлгэр сумын Гуулин тосгонд мод үржүүлгийн газрыг өргөтгөн, үйл ажиллагааг дэмжихэд, 15.0 сая төгрөгийг урд бүсийн сумдын нэн ховор, ашигт малтмалын судалгаа хийхэд, 10.0 сая төгрөгийг Дарив сумд ойн зурвас байгуулахад, 8,6 сая төгрөгийг Цогт сумын Баянтоорой тосгоны ГИДЦГ-ын “А” хэсэгт мазаалай баавгайн хамгаалал, биотехникийн арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

4-р зорилтын хүрээнд: Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоод хяналтын талаар БОГ, МХГ-аас мэдээллүүд ирсэн байна.

МХГ-аас ан амьтан агнах барихыг хориглосон хугацаанд хууль бус үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, хийсэн тухай илтгэх хуудсыг ирүүлсэн байна. Ан агнуурын чиглэлээр илэрсэн 31 зөрчилд нийт 2.1 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж 2.7 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьж 398 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг хийсэн байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудит хийж буй асуудлуудыг нэгтгэж тайланд тусгахдаа дараах арга зүйг ашиглаж баримтжууллаа.

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө бодитоор хийгдсэн эсэх
- Байгалийн нөөц ашиглаж байгаа иргэн аж ахуй нэгжийн нөөц ашигласны төлбөрийг мэргэжилтэнтэй тооцож үзэх
- Нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасны дагуу зарцуулсан эсэхийг үзэх
- Нөөц ашиглаж байгаа /ус/ иргэн аж ахуй нэгжтэй уулзаж зураг авалт, ажиглалт, ярилцлага хийх
- Хяналт шалгалтын баримт материалуудтай танилцаж, үр дүнг үзэх

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан ажилуудын зарцуулалтыг үзэх
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр сумдаас авч хэрэгжүүлсэн ажилуудтай танилцах
- Сумдын Засаг дарга, ИТХ-ийн бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар авч үзэх
- Хууль эрх зүйн актуудын хоорондоо нийцэж байгаа эсэх

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгоно.

- Монгол улсын үндсэн хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Усны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Амьтны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, нийцлийн аудитын багийн ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Г.Цэцэгмаа, шинжээч Ц.Сайханжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөр

Аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 01-аас эхэлж, 09 дүгээр сарын 29-ны өдөр дуусган тэргүүлэх аудиторроор хянаж баталгаажуулан 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр УАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын шийдвэр болон хавсралт хэсгүүдээс бүрдсэн.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өглөө.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох удирдлагуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Аудит хийхэд учирсан бэрхшээл:

- Аудитыг хийж гүйцэтгэхэд зардал төлөвлөгдөөгүй учир сумдаар явах боломжгүй байсан бөгөөд явуулсан судалгааны баримт материал хугацаа алдаж ирэх, дахин дахин шаардуулах, зарим сумдын байгаль орчны улсын байцаагч нарын хяналт шалгалтын материалууд байхгүй зэрэг асуудлууд тулгарч байсан.

БҮЛЭГ I: АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГА НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН БҮРЭН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.

1.1 Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь байгаль орчныг хамгаалах талаарх бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байгаа боловч сумдын ИТХ харилцан адилгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад¹ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн бүрэн эрхийн тусгайлан зааж өгсөн. Уг эрхийнхээ хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Хүснэгт №1: Аймгийн ИТХ-ийн хийж гүйцэтгэсэн ажлууд

Хэрэгжүүлэх бүрэн эрх	Хэрэгжилт
16.1.1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;	ИТХ-ын 2015 оны 02 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар аймагт 2015 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх 6 ажилд 55.5 сая төгрөг зарцуулахаар баталж хэрэгжилтийг хангуулсан байна. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 87 дугаар тогтоолоор “Усыг төлбөртэй болох” ² -оор баталжээ.
16.1.3/ байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;	ИТХ-ын 2015 оны 16 дугаар тогтоолоор Хантайширын нуруу орчмын зарим газар нутгийг түүх соёлын дурсгалт зүйлс, усан сан бүхий газрын эх бүрдэх хэсгийг хамгаалах зорилгоор 50 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан байна.
16.1.4/ хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох;	ИТХ-ын 2015 оны 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 6 газарт ³ хамгаалалтын бүс тогтоож талбайн хэмжээ, эргэлтийн цэгийг тодорхойлж өгсөн. Мөн 2 дугаар хавсралтаар хамгаалалтанд авсан газарт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хамгаалалтын горим ⁴ -ыг тогтоосон байна.
16.1.5/ байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх.	ИТХ-ын 2015 оны 10 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг дүгнэсэн.

¹ 16.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

² 1.Аймгийн нутаг дэвсгэрт ашиг олох зорилгоор уул уурхайн чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын унд болон ахуйн үйлчилгээнд ашигласан усыг нь говийн бүсийн нөөц багатай цэвэр усаа хэмнэх, зөв зохистой ашиглах зорилгоор төлбөртэй болгож төлбөрийн ногдуулалт хийж гэрээ байгуулан ажиллахыг эрх бүхий албан тушаалтнуудад даалгасугай.

³ Рашаант, Цахир булаг, Шаврын гол, Цахир ам, Бумбат, Дөтийн гол

⁴ “Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газарт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хамгаалалтын горим”

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1 дэх заалтад⁵ сумын ИТХ-ын бүрэн эрхийг тусгаж өгсөн.

Тодруулга: Аймгийн ИТХ, МХГ, Цагдаагийн газар, БОАЖГ, Есөнбулаг сумын ЗДТГ-ын хамтарсан ажлын хэсэг Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Өлийн хавчиг, Ялаат гэдэг газарт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг зогсоон Цагдаагийн газарт хэргийг хянуулахаар шилжүүлсэн байна.

Сумдын ИТХ-аас бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа харилцан адилгүй бөгөөд цаашид үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал: Ой, ургамлын нөөц ашиглах боломжгүй байхад сумдын ИТХ-аас орлогын төлөвлөгөө баталж оруулсан, хүн амын унд ахуйн зориулалтаар ашиглах усны төлбөрийг төрөөс хөнгөлсөн байхад төсөвт оруулахаар төлөвлөж, төсөвт байгууллагуудаас оруулсан байна. Тухайлбал: Алтай, Халиун, Цогт, Есөнбулаг, Жаргалан, Тайшир, Чандмань, Шарга, Эрдэнэ гэх мэт сумууд /хавсралт №2/

1.2 Аймаг Сумдын Засаг дарга нар бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллаж байгаа боловч сумдын Засаг дарга хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2-т Аймгийн Засаг дарга нь “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах” бүрэн эрхийг тусгаж өгсөн байна.

Аймгийн Засаг даргын БОАЖЯ-ны сайдтай байгуулсан гэрээнд байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөвлөн хэрэгжүүлэхээр 20 төсөл арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж ажилласан байна. Хийхээр төлөвлөсөн ажлуудаас улсын төсвийн хөрөнгөөр “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг “Эрүүл ус” ОНӨААТҮГ шалгарч гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ажил хийгдээгүй, агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн судалгаанд үндэслэн бохирдлыг бууруулах арга хэмжээг өөрийн аймгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх ажлууд хийгдээгүй байна. Гэрээний биелэлтийг аудитын явцад давтан тооцоолоход 84%-тай байна. /хавсралт №1/

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.2.1-17.2.10 дахь заалтуудад сумдын Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрхийг зааж өгсөн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа харилцан адилгүй бөгөөд цаашид үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байгааг харуулж байна. /хавсралт №3/

Сумдын Засаг дарга нарын байгаль орчныг хамгаалах чиглэлээр төлбөр ногдуулж, хяналт тавихаар томилсон албан тушаалтнууд үүргээ биелүүлэхгүй, сумд дүгнэлтгүй ус ашиглаж байгаа ААН, иргэнд төлбөр ногдуулж төсөвт төвлөрүүлдэггүй, түүнд ямар нэгэн арга хэмжээ аваагүй өдий хүртэл ажиллаж байна. Энэ нь тухайн сумын Засаг дарга байгаль хамгаалах тухай хуульд заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгааг илтгэж байна.

⁵ 17.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

БҮЛЭГ II: ОЙ, УРГАМАЛ, ХҮН АМЫН УНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАСАН УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ОРЛОГЫГ ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

2.1 Агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос бусад орлогыг үндэслэлтэй бодитой төлөвлөөгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөрийн орлогын төлбөр ногдох зүйлийг тооцож оруулахаар төлөвлөсөн.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5 дахь заалтад⁶ заасан орлогыг аймгийн нэгдсэн төсөвт, 23 дугаар зүйлийн 23.8.4⁷, 23.8.9⁸, 23.8.7⁹, 23.8.6¹⁰ дахь заалтуудад заасан орлогуудыг сумын төсөвт оруулахаар заасан.

• Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн талаар:

Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа усны төлбөрийн орлогыг аж ахуй нэгжээр төлөвлөн, 2015 онд 109.8 сая төгрөгийн төлбөрийн орлого оруулахаар төлөвлөжээ.

Сумууд хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөр 2015 онд 8.3 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж баталсан байна. Энэ нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дахь заалтад¹¹ заасан төлбөр төлөгчийг 100% хөнгөлж чөлөөлсөн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХ-ийн 2015 оны 03 сарын 27-ны 02 тоот тогтоолоор 14 аж ахуй нэгжээс 109.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж баталжээ. Эдгээрээс 9 аж ахуй нэгжтэй холбоотой 3.7 сая төгрөгийн ус ашигласны төлбөрийг ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл өгөөгүй оруулахаар тооцож баталжээ. Энэ нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18¹² дахь заалттай нийцэхгүй байна. Мөн 2015 онд “Марко Поло” ХХК-аас 60.0 сая төгрөг, “Алтайн Хүдэр” ХХК-аас 16.0 сая төгрөг орно гэж төлөвлөсөн хэдий ч эдгээр компаниуд нь 2015 онд үйл ажиллагаа явуулаагүйн улмаас орлогын төлөвлөгөө 76.0 сая төгрөгөөр тасарчээ. /хавсралт №4/

Харин 2015 онд ус ашиглах дүгнэлт гаргуулан үйл ажиллагаа явуулж байгаа 14 аж ахуй нэгжтэй холбоотой 70.5 сая төгрөгийн төлбөрийн бодит орлого орох боломжтой байжээ. /хавсралт №5/

• Агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн талаар:

ЗГ-ын 2014 оны 377-р тогтоолыг үндэслэн, БОАЖЯ-ны сайдын 2014 оны А-426 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар тус аймагт Аж богдын агнуурын бүс нутагт 2015 онд 6 тэх агнах зөвшөөрлийг олгосон байна. Үүний дагуу сумын ИТХ 20,801.4 мянган төгрөгийг ан агнуурын орлогоос орохоор төлөвлөж баталсан байна.

• Ой, ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн талаар:

⁶ Үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр ашигласан усны төлбөр

⁷ агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах барих зөвшөөрлийн хураамж

⁸ хүн амын унд ахуйн хэрэгцээний зориулалтаар ус рашаан ашигласны төлбөр

⁹ ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого

¹⁰ байгалийн ургамал ашигласны төлбөр

¹¹ хүн амын унд ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах

¹² Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно

Говь-Алтай аймгийн хувьд 2014-2016 онд ой, ургамлын нөөц ашиглахаар сумдын Засаг дарга, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зөвшөөрөл олгогдоогүй, ойн нөөц ашиглах боломжгүй хамгаалалтын I ойн бүс¹³ нутагт хамаарагддаг байна. Гэтэл 2014 онд 5.2 сая төгрөг, 2015 онд 5.0 сая төгрөг, 2016 онд 2.8 сая төгрөг нийт 13.0 сая төгрөгийн орлого оруулахаар сумдын ИТХ-аас баталсан байна. Энэ нь бодит байдалд нийцээгүй, үндэслэлгүй төлөвлөлт хийгдэж байгааг харуулж байна.

Хүснэгт № 4: Ой, ургамлын нөөц ашигласны орлогын төлөвлөлтийн судалгаа /мян.төг/

Нөөцийн төрөл	2014 он		2015 он		2016 он	
	Төлөвлөх дүн	Батлагдсан төсөв	Төлөвлөх дүн	Батлагдсан төсөв	Төлөвлөх дүн	Батлагдсан төсөв
Ойн нөөц	0	5,000.0	0	4,686.0	0	2,800.0
Ургамлын нөөц	0	200.0	0	400.0	0	0
Дүн	0	5,200.0	0	5,086.0	0	2,800.0

2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

• Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийн талаар:

1. Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 2014 онд 11.6 сая төгрөгөөр, 2015 онд 8.1 сая төгрөгөөр баталж байсан бол 2016 онд 1.7 сая болж буурсан байна. Гүйцэтгэлээр орлого орсон мэт харагдаж байгаа нь төсөвт байгууллагуудын цэвэр бохир усны төлбөрийн зардлаас шилжүүлсэн мөнгө байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1¹⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 3.3 сая төгрөгийг 2014 онд Алтай сумын ОНХО-д, 3.4 сая төгрөгийг 2015 онд Есөнбулаг сумын ОНХО-д, 1.2 сая төгрөгийг 2015 онд Дэлгэр сумын ОНХО-д тус тус төвлөрүүлж, зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.6 дахь заалт /Аймаг нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ/, 23.6.5 дахь заалт /үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр/-ыг зөрчсөн байна.

Хүснэгт № 5: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийн судалгаа /мян.төг/

Он	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл		Зөрүү	
	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	Хүн амын унд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөр	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	Хүн амын унд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөр	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	Хүн амын унд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөр
2014	59,500.00	11,650.00	69,737.40	6,567.8	-10,237.4	+5,082.2
2015	110,072.90	8,100.00	65,967.70	4,942.5	+47,526.3	-264.6
2016	75,922.10	1,750.00	91,352.10	325.00	-15,430.0	1,425.0

¹³ Байгаль орчны сайдын 1996 оны 230 дугаар тогтоол.

¹⁴ хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсэнд ашигласан усны төлбөр төлөгчийг усны төлбөрөөс 100% чөлөөлнө

дүн	245,495.0	21,500.0	227,057.2	11,835.3	21,858.9	6,771.8
-----	-----------	----------	-----------	----------	----------	---------

Мөн ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй аж ахуй нэгжүүдээс 2014 онд 8.0 сая төгрөг /бусад ААН-ээс оруулахаар бөөн дүнгээр төлөвлөсөн/, 2015 онд 3.7 сая төгрөг, 2016 онд 18.7 сая төгрөгийн ус ашигласны төлбөрийн орлогыг оруулна гэж төлөвлөсөн байна.

- Усны нөөц ашиглан үйл ажиллагаа явуулсан ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн ашигласан усны хэмжээг экологи, эдийн засгийн үнэлгээгээр төлөх татварыг тооцвол хамгийн багадаа дараах байдалтай байна.

Хүснэгт № 6: Ус ашигласан аж ахуй нэгжүүдийн судалгаа /мян.төг/

Дүгнэлт гаргуулсан эсэх	2014 он			2015 он			2016		
	Төлбөл зохих татвар	Төлсөн татвар	Зөрүү	Төлбөл зохих татвар	Төлсөн татвар	Зөрүү	Төлбөл зохих татвар	Төлсөн татвар	Зөрүү
Дүгнэлттэй	128,019.1	128,119.3	-100.0	70,276.0	48,372.9	+22,031.0	97,449.4	31,701.0	+65,748.0
Дүгнэлтгүй	6,101.3	2,259.8	+3,668.8	19,537.8	6,945.5	+12,592.3	22,918.6	618.9	+22,299.3
дүн	134,120.4	130,379.1	+3,568.5	89,814.6	55,318.4	+34,496.1	120,367.6	32,319.9	88,047.7

Дээрх судалгаанаас харахад дүгнэлттэйгээр ус ашиглаж байгаа аж ахуйн нэгжүүдээс 2015 онд 21.5 сая төгрөг, 2016 онд 65.7 сая төгрөг нийт 87.2 сая төгрөгийн орлого нэмж орох боломжтой байна. Эдгээрээс Татварын хэлтэс нь Тайшир Гуулин УЦС ХХК-аас 2015 онд 17.9 сая төгрөгийн авлагатай ба 69.8 сая төгрөгийн орлогыг оруулах ААНБ нь бүртгэлгүй, өглөг авлагаар бүртгээгүй байна. /хавсралт №5, 6, 7/

Харин ус ашиглах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй ус ашигласан аж ахуй нэгжүүдийн ашигласан усны хэмжээг нормын дагуу тооцвол: 2014 онд 3.6 сая төгрөг, 2015 онд 12.6 сая төгрөг, 2016 онд 19.5 сая төгрөг нийт 35.7 сая төгрөгийн орлого хамгийн багадаа нэмж орох боломжтой бөгөөд эдгээр аж ахуй нэгжүүд дээр Усны тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцох нь зүйтэй байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд дүгнэлтгүйгээр ус ашигласаар ирсэн нь хяналт сул байсныг харуулж байна. /хавсралт №5, 6, 7/

Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан ажиглалт хийн, ярилцлага хийж явахад: “Мандал Голомт” ХХК, “Арвин бэлт” ХХК, “Ентүм трейвэл” ХХК, “Талст” машин угаалгын газрууд нь зөвшөөрөлгүйгээр хашаандаа худаг гарган ашиглаж байна. Энэ нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1815 дахь заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ. Иймд эдгээр аж ахуй нэгжүүдэд Усны тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцох саналыг МХГ-т хүргүүлэхээр шийдвэр гаргалаа.

- БОГ хууль бус нөхөн сэргээлтээр 2015 онд ус ашигласан 7 аж ахуйн нэгжтэй холбоотой 221.7 сая төгрөгийн ус ашигласны зөрчлийг илрүүлж МХГ-т хүргүүлсэн байна. МХГ эдгээр байгууллагыг цагдаа руу шилжүүлсэн гэх бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдэж байгаа гэсэн тайлбар өгсөн. /хавсралт № 8/

- Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл**

15 Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно

Байгаль орчин ногоон хөгжлийн аялал жуулчлалын сайдын 2014 оны А-426 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар тус аймагт Аж богдын агнуурын бүс нутагт 2015 онд 6 тэх агнах зөвшөөрлийг олгосон байна. Үүний дагуу сумын ИТХ 20.8 сая төгрөгийг ан агнуурын орлогоос орохоор төлөвлөж баталсан бөгөөд гүйцэтгэлээр 20.8 сая төгрөг орсон байна.

- **Ургамал, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл**

Хүснэгт № 7: Ургамал, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл

Нөөцийн төрөл	2014 он			2015 он			2016 он		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Бодит Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Бодит Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Бодит Гүйцэтгэл
Ойн нөөц	5,000.0	5,083.5	0	4,686.0	4,093.0	0	2,800.0	399.4	0
Ургамлын нөөц	200.0	0	0	400.0	25.9	0	0	0	0
Дүн	5,200.0	5,083.5	0	5,086.0	4,118.9	0	2,800.0	399.4	0

Говь-Алтай аймгийн хувьд 2014-2016 онд ой, ургамал ашигласны орлогын төлөвлөлт нь хууль бус, харин гүйцэтгэлийг хангахын тулд хүү торгуулийн орлогыг зүйл анги зөрүүлэн тайлагнаж, хий гүйцэтгэл гаргасан байна.

Халиун сум нь ИТХ-ын 2015 оны 20 дугаар тогтоолоор 2015-2016 оны өвөлжөөлтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд сумын албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэгцээнд ой цэвэрлэх журмаар үер усны улмаас унанги мод, өгөрсөн хожуул бэлтгэх дээд хэмжээг 230м³ мод бэлтгэх тогтоол гаргасны дагуу сумын Засаг даргын 2015 оны А/88 тоот захирамжаар 218 м³ түлшний мод бэлтгэж, ойн баялаг ашигласны төлбөр хураамжийг ногдуулж 1.6 сая төгрөгийн орлого оруулсныг бодит орлого гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Энэ нь: Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹⁶, 7.2¹⁷, 25.1¹⁸-д заасан заалтуудыг зөрчсөн байна.

БҮЛЭГ III: ОЙ, УС, УРГАМАЛ, АМЬТНЫГ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД 67.3 САЯ ТӨГРӨГИЙГ ХУУЛИЙН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

3.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаар мөрдөөгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах доод хувь хэмжээг тогтоож өгсөн байна. Үүний дагуу 2015 онд усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 70.9 сая төгрөг

¹⁶ Ойн зохион байгуулалтыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ

¹⁷ Ойн сангийн тооллого, зохион байгуулалтыг 10 жил тутамд нэг удаа хийж, түүний нөөц, төлөв байдлыг улсын хэмжээнд шинэчлэн тогтооно.

¹⁸ Ойн өсөлтийг сайжруулах, түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ойд хийх арчилгаа, цэвэрлэгээг ойн мэргэжлийн байгууллага улс, орон нутгийн төсөв, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн ойддоо өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ

орсноос үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр болох 65.9 сая төгрөгийг бодит орлого гэж хүлээн зөвшөөрч, ой, ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодит орлого гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. /хавсралт № 9/

Иймд байгалийн ургамал, ойн нөөц ашигласны төлбөрийн бодит орлого ороогүй байхад нэн ховор ургамлын судалгааны ажилд 15.0 сая төгрөгийг, ойн зурвас байгуулах, мод үржүүлгийн газрыг өргөтгөх ажилд 20.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар аймгийн ИТХ-аас баталсан байна. Харин ус ашигласны төлбөрийн орлогоос 19%-ийг зарцуулахаар баталсан нь доод хязгаараас 16%-иар дутуу байна. /хавсралт № 10/

Хүснэгт №8: Төлбөрийн орлогоос зарцуулах хувь хэмжээ /мян.төг/

	Төлбөр ногдох зориулалт	2015 онд төвлөрүүлсэн орлого	Зарцуулах доод хязгаар	Зарцуулахаар баталсан	Зөрүү /илүү бол-, дутуу бол +/
1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого;	-	-	15,000.00	(15,000.00)
2	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого;	65,968.7	23,089.0	12,000.00	11,089.0
3	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;	-	-	20,000.00	(20,000.00)
4	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого;	20,801.0-	10,400.70	18,980.30	(8,579.60)
	Нийт дүн	83,348.00	33,489.7	65,980.30	(32,490.6)

3.2 Ус ашигласны төлбөрийн орлого, газрын төлбөрийн орлогоос 20.0 сая төгрөгийг 3.2-т заасан арга хэмжээнд зарцуулсан нь зориулалт бус байна.

Аймгийн ИТХ-аас баталсан 10.0 сая төгрөгийг Дарив сумын Ихэсийн голд “Ойн зурвас байгуулах” ажилд, 10.0 сая төгрөгийг Бигэр, Дэлгэр сумын Гуулин тосгоны “Мод үржүүлгийн талбайг өргөжүүлэх” ажилд тус тус зарцуулсан нь ЗГ-ын 2014 оны 43 дугаар тушаалын 3.3.4¹⁹ дэх заалтад заасан арга хэмжээнд нийцэж байгаа хэдий боловч усны нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын төлбөрийн орлогын эх үүсвэрээс зарцуулсан нь зориулалт бус байна. Шарга сумын мод үржүүлгийн ажил хийгдээгүй тасарсан байна. /хавсралт № 11/

3.3 Ус рашаан ашигласны төлбөрийн орлогоос 19%-ийг журамд заасан арга хэмжээнд зарцуулсан байна.

Тайлант 2015 онд усны нөөц ашигласны төлбөрөөс 65.9 сая төгрөгийн орлого орсон бөгөөд зарцуулах доод хязгаар нь 23.0 сая төгрөг бөгөөд гүйцэтгэлээр 12.0 сая төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын 3.2.3²⁰, 3.2.5²¹ дахь заалттай нийцэж байна.

¹⁹ ойн үр бэлтгэх ой сонгох, плантаци байгуулах, үр, боргоцой бэлтгэж боловсруулах, тарьц, суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, байгалийн сэргээн ургалтад туслах, ойн зурвас, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, голын эх, эрэг дагуу мод тарьж төгөл байгуулах, баянбүрд бий болгох, хууль бус мод бэлтгэх зөрчлийг бууруулах, хяналт шалгалт хийх арга хэмжээнд тус тус зарцуулна.

²⁰ Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийх, тохижуулах;

²¹ усны сав газрын байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, цас, борооны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, рашаан, гол мөрний урсац бүрэлдэх эх, булаг шанд, баянбүрдийг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээ хугацаа хоцорч хүлээлгэн өгсөнд Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2015 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар 0.268 сая төгрөгийн алданги тооцон төлбөрийн акт тогтоосон бөгөөд шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. /хавсралт № 12/

3.4 Ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 18.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулахаар баталжээ.

- Байгалийн ургамлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга, ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно” гэж заасан бөгөөд Говь-Алтай аймгийн хувьд сумдын Засаг дарга, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас зөвшөөрлийг 2015 онд ямар нэгэн иргэн, хуулийн этгээдэд олгоогүй байхад аймгийн ИТХ-аас 15.0 сая төгрөгийг урд бүсийн нэн ховор, ховор ашигт ургамлын судалгааны ажилд баталж, түүнийг зарцуулжээ. Энэ нь ЗГ-ын 2014 оны 43-р тогтоолын 3.1.1²² дэх заалттай нийцэж байгаа хэдий ч усны нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын төлбөрийн орлогоос зарцуулжээ.
- Аймгийн ИТХ-аас 2015 онд Мазаалай баавгайн хамгаалал, биотехникийн арга хэмжээнд 8.6 сая төгрөгийг зарцуулахаар баталж, гүйцэтгэлийг хангуулсан байна.
- Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т “Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтооно”, 26.3-т “Тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалтын дагуу Говь-Алтай аймгийн хувьд 2014 онд спорт болон олзворын агнуурын зориулалтаар 10 тэх, ахуйн зориулалтаар 90 саарал чоно агнах, 2015 онд 6 тэх, 2016 онд 17 тэх агнах зөвшөөрлийг олгосон байна. Үүний дагуу Алтай сумд 2014 онд 6 иргэнд 10 тэх агнах зөвшөөрөл олгогдон 8 тэх агнаж 32.1 сая, 2015 онд 4 иргэнд 6 тэх агнах зөвшөөрөл олгогдон 4 тэх агнаж 20.8 сая, 2016 онд 7 иргэнд 10 тэх агнах зөвшөөрөл олгогдон одоогийн байдлаар 4 тэх агнагдан 26.2 сая, Жаргалан сумд 4 иргэнд 5 тэх агнах зөвшөөрөл олгогдон 3.9 сая төгрөг нийт 83.1 сая төгрөгийг сумдын орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Цогт сумд зөвшөөрөл олгогдоогүй. Ахуйн зориулалтаар 90 чоно агнаагүй байна. /хавсралт №10/

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувиас доошгүй зардлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар тогтоож өгчээ.

Алтай сумын хувьд 2014, 2015 онд төсөвт орж ирсэн төлбөрийн орлого 52.9 сая төгрөгөөс 39.2 сая төгрөгийг зарцуулахаар сумын ИТХ-аар баталсан байна. Харин

²² нэн ховор, ховор ургамлын нөөцийн судалгаа шинжилгээ;

Алтай, Цогт, Жаргалан сумдад 2016 онд төвлөрсөн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг одоогоор зарцуулаагүй байна.

Алтай сум нь одоогийн байдлаар хууль тогтоомжийн дагуу 52.9 сая төгрөгийг зарцуулах боломжтойгоос 12.3 сая төгрөгийг зарцуулж 40.6 сая төгрөгийг зарцуулаагүй үлдэгдэлтэй байна. /хавсралт №13/

“Ан агнуурын менежментийн төлөвлөгөө”-г батлахдаа дараах ажлуудад нийт 18.2 сая төгрөг баталсан нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт²³, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 4 дүгээр сарын 27-ний өдрийн А-115 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр нь урамшуулах тухай журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт²⁴, 7.4 дэх заалт²⁵-уудыг тус тус зөрчсөн байна.

Мөн Алтай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Ан агнуурын менежментийн төлөвлөгөө” батлах тогтоолоор “агнуурын ан амьтны тооллого зохион байгуулах зардал 1.0 сая төгрөг, Наран, Цав, Хармагтай зэрэг газруудад булаг шандуудын эх ундрагыг хамгаалах зардалд 3.0 сая төгрөгийг баталсан боловч уг зардлаас зориулалт бусаар 2.0 сая төгрөгийг хүүхдийн чуулган зохион байгуулахад зарцуусан зөрчил илэрлээ.²⁶

Хүснэгт №9: Ан агнуурын орлогоос хууль журамд нийцэхгүй ажлуудыг баталсан байдал

ИТХ-ийн тогтоол	Төслийн нэр	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Алтай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар	“Идэвхтэн байгаль хамгаалагчийн Баянцагаан болон Урт багуудад тус бүр нэгийг гэрээгээр ажиллуулсан урамшуулах”	1.6	0.1
	“Агнуурын бүс нутаг дахь алслагдсан малчид иргэдийг холбоожуулах” зардалд	9.0	
2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар, 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралтаар	Гэрээтэй идэвхтэн байгаль хамгаалагчдын урамшуулал”	1.6	
	Ав зохион байгуулахад шатахууны дэмжлэг”	1.0	
	“Худаг засвар	2.5	
	“ОНСТанхимын тохижилт	2.5	
	Нийт дүн	18.2	0.1

3.5 Хүн амын унд ахуйн зориулалтаар ашиглаж байгаа усны төлбөрийн орлогыг хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамруулаагүй, орлого оруулахаар төлөвлөж оруулсан байна .

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан ой, ургамлын орлогыг төлөвлөх, зарцуулах боломжгүй бөгөөд, ан амьтны нөөц

²³ “3.4 Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.2-т заасныг үндэслэн тухайн суманд: 3.4.1. аймгийн болон агнуурын бүс нутгийн ан, агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх, сурталчилах, нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хэрэгжүүлэх; 3.4.2. амьтны амьдрах орчинг нөхөн сэргээх, тэтгэх, агнуурын амьтны судалгаа, мониторинг хийх; 3.4.3. Амьтны тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах сургалт, сурталчилгаа, хяналт шалгалт хийх арга хэмжээнд тус тус зарцуулна”

²⁴ 7.1.1-т “Байгалийн нөөц баялгийг хууль бусаар бэлтгэсэн, агнасан, түүсэн тухай мэдээлсэн, илрүүлсэн идэвхтэн байгаль хамгаалагчийг тухайн зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар шагнаж урамшуулна”,

²⁵ 7.4-т “Байгалийн нөөц баялгийг хууль бусаар бэлтгэсэн, түүсэн, агнасны улмаас учирсан хохиролд тавигдсан нөхөн төлбөрөөс байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгийн 20 хувиар тухайн зөрчлийг илрүүлэн, нөхөн төлбөрийг барагдуулсан идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулна”

²⁶ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”,

ашигласны төлбөрийн орлогоос хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдах иргэн ААН байхгүй болно. Харин хүн амын унд ахуйн зориулалтаар ашиглаж байгаа ус нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1²⁷ дэх заалтад зааснаар хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамрагдах ёстой гэтэл 2014-2016 онд сумдад хүн амын унд ахуйн зориулалтаар ашиглаж байгаа усны төлбөрийн орлогыг оруулна гэж төлөвлөж, оруулсан байна.

БҮЛЭГ IV: ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

4.1 Хяналтыг хэрэгжүүлэх сумдын байгаль хамгаалагчын харьяалал нь тодорхой бус байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.7-д “байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, **тэдгээрт хяналт тавих ажиллагаа** хамаарна” хэмээн тодорхойлсон. Уг хуулийн хүрээнд УИХ нь “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлах тэдгээрийн биелэлтэд хяналт тавих”²⁸, Засгийн газар нь хяналт зохион байгуулах²⁹, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь “хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих”³⁰, Аймаг, сумын ИТХ, Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв батлах, биелэлтэд хяналт тавих³¹, Багийн Иргэдийн Нийтийн хурал, Засаг дарга нь нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих бүрэн эрхийг хуулиар тусгайлан заасан.

²⁷ Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах

²⁸ **13 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 3/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлах тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

²⁹ **14 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ амьтан, ургамал, түүнчлэн байгалийн гаралтай түүхийг эд экспортлох, импортлоход хил, гааль, хорио цээрийн хяналтыг зохион байгуулах;

³⁰ **15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15/ байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

³¹ **16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх**

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих; 3/ байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

Мөн хуульд Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэхээр зааж орон нутагт улсын байцаагч, байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч³² нар ажиллах эрх зүйн орчинг тусгаж өгсний зэрэгцээ аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын зүгээс хяналт тавих эрх, үүргийг тус тус тусгасан.³³

Түүнчлэн Амьтны тухай хуулийн 5, 21 дүгээр зүйл, Ургамал хамгааллын тухай хуулийн 7, 8, 9, 10, 15 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 13, 17, 18, 25, 39, 42 дугаар зүйл, Усны тухай хуулийн 10, 11, 13, 15, 17, 18, 19, 20 дугаар зүйлүүд болон Засгийн газрын тогтоол, Сайдын тушаалуудаар тусгайлсан эрх бүхий субъектийг тусгасан нь байгаль орчны хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн байна.

Говь-Алтай аймгийн хувьд аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч нар нь холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчны хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд³⁴ аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэж байна³⁵.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч/цаашид “улсын байцаагч” гэх/ болон байгаль хамгаалагч тус тус ажиллана” тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8-т улсын байцаагч “байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх” эрхтэй гэж заасан. Эндээс үзвэл байгаль хамгаалагч нь Мэргэжлийн хяналтын газрын хяналтанд ажиллахаар зохицуулсан байна.

Гэтэл уг хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.4-т “байгаль хамгаалагчийг . . . улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга” томилж чөлөөлнө гэж заасан бөгөөд бодит байдалд Байгаль орчин аялал жуулчлалын газраас байгаль хамгаалагчийг томилж, удирдлагаар ханган ажиллаж байна.

Иймд сумдын байгаль хамгаалагч нарын харьяаллын асуудлыг хуульд тодорхой болгож өгөх талаар Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газарт санал хүргүүлээ.

³² Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 4 дүгээр сарын 27-ний өдрийн А-115 дугаар тушаалын хавсралт “Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр нь урамшуулах тухай журам”

³³ 31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна: 2/ эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх;

32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох 1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

³⁴ Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоол, 2016 оны 09 дүгээр тогтоол.

³⁵ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-76 тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.1 дэх заалт.

4.2 Дотоод хяналт хангалтгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт/ *Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ*/-д байгаль орчны хяналтыг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой зааж өгсөн байна. Үүний дагуу аудитад 2015 онд хийсэн МХГ-ын байгаль орчны асуудал хариуцсан ажилтнуудын хяналт шалгалтын материал, 16 сумдын улсын байцаагч нарын хяналт шалгалтын материал хамрагдлаа.

Сумдын улсын байцаагч нарыг шалгуулахдаа шаардлагатай баримт материалыг заавал авч ирэхийг, албан тоотоор МХГ-т хүргүүлсэн. Гэтэл сумдын улсын байцаагч нар нь баримт материал дутуу, ямарч нотлох баримтгүйгээр ирсэн. Тухайлбал: Дэлгэр, Жаргалан, Тонхил, Халиун, Эрдэнэ, Бугат гэх мэт

Сумдын улсын байцаагч нар хяналт шалгалт хийсэн гэх тайлбарыг өгч байсан бөгөөд нотлох баримтгүй тул МХГ-т сумдын хүргүүлсэн хяналтын баримт материалыг авч үзсэн.

Хүснэгт №10: Улсын байцаагч нарын хяналт шалгалтын тоо, илрүүлэлт, үр дүн /2015 он/

Улсын байцаагч	Хяналт ын тоо	Зөрчлийн утга	Тогтоосон торгууль шийтгэл /сая.төг/	Шийдвэрлэсэн байдал
1.МХГ-ын байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч	5	1. Яргайтын застав нь хууль бусаар заг түүж бэлтгэсэн 2. Баян-Уул, Тонхил, Цээл, Есөнбулаг,Бугат, Тайшир, Төгрөг, Шарга сумдад хууль бусаар тарвага агнасан. Жич: 3 хяналт шалгалтаар зөрчил илрээгүй.	1. 4.5 сая төгрөгийн торгууль, нөхөн төлбөр ногдуулсан 2. 52 ш тарвага,34 хавх, 27 буу хураасан	- 2.9 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж, 1.6 сая төгрөгийг ШШГА-нд шилжүүлсэн. - Цагдаагийн газарт шилжүүлсэн
2.Сумдын улсын байцаагч	104	1. Есөнбулаг сум дээр ус ашиглалтын байдалд хяналт шалгалт хийсэн 2. Шарга, Алтай сумдад заг түүсэн 3. Алтай сумд хууль бусаар тарвага агнасан	1. 1.0 сая төгрөгийн торгууль шийтгэл ногдуулсан 2. 0.404 сая төгрөгийн зөрчилд торгууль ногдуулсан. 3. 0.380 сая төгрөгийн торгууль ногдуулсан.	Есөнбулаг сумын дансанд төвлөрүүлсэн Сумдын дансанд төвлөрүүлсэн Сумдын дансанд төвлөрүүлсэн байна.
Нийт дүн	109		6.3 сая төгрөгийн торгууль ногдуулсан	4.7 сая төгрөгийн торгууль биелэгдсэн

Сумдын хувьд 2015 онд ан агнуурын чиглэлээр 1 удаагийн хяналт шалгалт хийж - 0.384 сая төгрөг, ойн нөөц ашиглалтын чиглэлээр 2 удаагийн хяналт хийж 0.404 сая төгрөг, усны чиглэлээр 1.0 сая төгрөг нийт 1.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

МХГ-ын хувьд ан агнуурын чиглэлээр 3 удаагийн хяналт шалгалт хийн, 52 ш тарвага, 34 хавх, 27 буу хураан, Цагдаагийн газарт шилжүүлсэн байна. Ойн нөөц ашиглалтын чиглэлээр 1 удаагийн хяналт шалгалт хийж, 4.5 сая төгрөгийн торгууль, нөхөн төлбөр ногдуулсан ба үүнээс төлөгдсөн нь 2.9 сая төгрөг байна.

Эндээс үзвэл сумдын улсын байцаагч нарын байгаль орчныг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүрэг хангалтгүй байгаа нь тухайн байгууллагын хийсэн хяналт шалгалтын тоо, илрүүлэлт, улсын байцаагч нартай хийсэн ярилцлага, аудитаар илэрсэн зөрчлөөс харагдаж байна. Тухайлбал:

2014 онд 29 ААНБ, 2015 онд 35 ААНБ, 2016 онд 24 ААНБ ус ашиглах дүгнэлтгүйгээр үйл ажиллагаагаа явуулсаар байгаа нь байгаль орчны хяналтын улсын байцаагч нар нь байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27.1.3 ³⁶, 27.1.7 ³⁷ -д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахгүй байгааг харуулж байна/Хавсралт № 14, 15/

- **Хамтарсан хяналт шалгалтын талаар**

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2015 оны 10 дугаар сарын 11-ээс 12 сарын 01-ны хооронд Хөгжлийн бодлогын хэлтэс, МХГ, Татварын хэлтэс, Стандарт Хэмжил зүйн хэлтэс, БОАЖГ, Есөнбулаг сумтай хамтарсан шалгалтыг ус ашиглалт, зарцуулалт, тоолууржуулалтын байдалд хяналт шалгалтыг хийжээ. Шалгалтын явцад Эн Си Ти Жи ХХК-ын зөвшөөрөлгүй ашигласан усны нөхөн төлбөр 3.7 сая төгрөгийг ногдуулж, нөхөн төлүүлсэн байна.

Бусад хууль бус нөхөн сэргээлтээр ус ашигласан аж ахуй нэгжүүдтэй холбоотой 306.9 сая төгрөгийн нөхөн төлбөрийг тооцоолон МХГ-т албан бичгээр хүргүүлсэн байна. МХГ нь хууль бус нөхөн сэргээлтээр ус ашигласан 7 аж ахуй нэгжийг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн гэх бөгөөд мөрдөн байцаалтын ажил хийгдэж байгаа гэсэн тайлбарыг өглөө.

Мөн зөвшөөрөлгүй, тоолуургүй ус ашиглаж байгаа иргэн аж ахуйн нэгжийн зөрчлийг арилгуулахаар 12 албан шаардлагыг зөрчил гаргасан байгууллагуудад хүргүүлэн ажиллажээ. Үүний дагуу 6 аж ахуй нэгж тоолууржуулсан байна.

Иймд ус ашиглах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүй дур мэдэн шуудуу татсан үйл ажиллагааг таслан зогсооход хууль, хяналтын байгууллагууд эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Аудитаас дараах зөрчил илэрлээ.

Аудитаар нийт 168.0 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн, 1 заалт зөвлөмж, 168.0 сая төгрөгийн зөрчилд 14 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 4 аж ахуй нэгжид хариуцлага тооцох санал хүргүүлж, 115.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 15 санхүүгийн бус үр өгөөж бүртгэлээ.

1. Бодит байдал дээр сумдын байгаль хамгаалагч нарыг Байгаль орчны газар томилон, түүнд харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байна.
2. Сумууд нь хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 2014 онд 11.5 сая төгрөгөөр, 2015 онд 8.1 сая төгрөгөөр, 2016 онд 1.7 сая төгрөгөөр нийт 21.3 сая төгрөгөөр баталсан байна
3. Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 3.3 сая төгрөгийг 2014 онд Алтай сумын ОНӨО-д, 3.4 сая төгрөгийг 2015 онд Есөнбулаг сумын ОНӨО-д, 1.2 сая төгрөгийг 2015 онд Дэлгэр сумын ОНӨО-д тус тус төвлөрүүлсэн байна.
4. Ой, ургамал ашигласны төлбөрийн орлогыг тооцохдоо бодит байдалд нийцээгүй төлөвлөлтийг хийж 2014-2016 онд 13.0 сая төгрөгийн орлого оруулахаар сумдын ИТХ-аас баталсан байна
5. Байгаль орчин аялал жуулчлалын газрын усны мэргэжилтэнтэй тулган тооцоолоход: Ус ашиглах дүгнэлттэй, зөвшөөрөлтэй ус ашиглаж байгаа аж ахуй нэгжүүдээс 2015 онд 4.1 сая төгрөг, 2016 онд 65.7 сая төгрөг нийт 69.8 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, ногдуулалт хийгээгүй байна.
6. Ус ашиглах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй ус ашигласан аж ахуй нэгжүүдийн ашигласан усны хэмжээг нормын дагуу тооцвол: 2014 онд 3.6 сая төгрөг, 2015 онд 12.6 сая төгрөг, 2015 онд 19.5 сая төгрөг нийт 35.7 сая төгрөгийн орлого

³⁶ хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, тодорхой хугацаагаар үйл ажиллагааг нь түдгэлзүүлэн зогсоох

³⁷ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заасан захиргааны шийтгэл, нөхөн төлбөр ногдуулах, төлбөрийг барагдуулах

төгрөгийн орлого хамгийн багадаа орох боломжтой бөгөөд эдгээр аж ахуй нэгжүүд дээр ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

7. "Мандал Голомт" ХХК, "Арвин бэлт" ХХК, "Ентүм трейвэл" ХХК, Талст машин угаалгын газрууд нь зөвшөөрөлгүйгээр хашаандаа худаг гарган үйл ажиллагаа явуулж байна.
8. Халиун сумын ИТХ-ын 2015 оны 20 дугаар тогтоолоор мод бэлтгэх хэмжээг 230м3 -аар тогтоон, үүний дагуу сумын Засаг даргын 2015 оны А/88 тоот захирамжаар 218 м3 түлшний мод бэлтгэж, 1.6 сая төгрөгийн орлого оруулсан байна.
9. Алтай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Ан агнуурын менежментийн төлөвлөгөө"-г батлахдаа "Идэвхтэн байгаль хамгаалагчийг Баянцагаан болон Урт багуудад тус бүр нэгийг гэрээгээр ажиллуулан урамшуулах" зардалд 1.6 сая, "Агнуурын бүс нутаг дахь алслагдсан малчид иргэдийг холбоожуулах" зардалд 9.0 сая төгрөгийг, 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар, 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралтаар "Ан агнуурын зардлын төсөв" батлахдаа "Гэрээтэй идэвхтэн байгаль хамгаалагчдын урамшуулал"-ын зардалд 1.6 сая, "Ав зохион байгуулахад шатахууны дэмжлэг"-ийн зардалд 1.0 сая, "Худаг засвар"-ын зардалд 2.5 сая, "ОНСТанхимын тохижилт"-ын зардалд 2.5 сая, нийт 18.2 сая төгрөгийг баталсан байна.
10. Алтай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Ан агнуурын менежментийн төлөвлөгөө" батлах тогтоолоор "агнуурын ан амьтны тооллого зохион байгуулах зардал 1.0 сая төгрөг, Наран, Цав, Хармагтай зэрэг газруудад булаг шандуудын эх ундрагыг хамгаалах зардалд 3.0 сая төгрөгийг баталсан боловч уг зардлаас зориулалт бусаар 2.0 сая төгрөгийг хүүхдийн чуулган зохион байгуулахад зарцуусан.
11. Идэвхтэн байгаль хамгаалагч Т.Батсуурийг 0.144 сая төгрөгөөр урамшуулал олгохдоо илрүүлсэн зөрчилд үндэслээгүй.

Аудитаас дараах шийдвэрийг хүргүүлж байна.

ҮАГ-т хүргүүлэх санал

1. Байгаль хамгаалагчийн харьяалалыг тодорхой болгох

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга С.Гансэлэм

1. Хууль тогтоомжийн дагуу байгаль хамгаалагчийг томилж, бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангаж ажиллах

Албан шаардлага

СХСТ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Жаргалсайхан танаа

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль эрх зүйн дагуу үндэслэлтэй, үнэн зөв төлөвлөж, гүйцэтгэлийг ханган ажиллах

Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Энхтуяа танаа

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус ашигласан нэр бүхий ААНБ-аас усны нөөц ашигласны төлбөр 69.8 сая төгрөгийг 2016 оны 12 сарын 20-ны дотор төсөвт төвлөрүүлж

Тайшир, Цогт, Алтай, Халиун, Жаргалан, Есөнбулаг сумдын ИТХ-ын дарга нарт

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, эрх зүйн дагуу үндэслэлтэй төлөвлөж, баталж байх

МХГ-ын дарга Б.Түмбаатар танаа

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй ус ашиглаж байгаа иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, нөхөн төлбөрийг хуулийн дагуу ногдуулж, төсөвт төвлөрүүлэх

2. Зөвшөөрөлгүй худаг гаргасан 4 аж ахуйн нэгж дээр хуульд заасны дагуу хариуцлага тооцож биелэлтийг 2016 оны 10 сарын 10-ны дотор Аймгийн Аудитын газарт ирүүлэх

Халиун сумын ИТХ-ийн дарга Г.Бадарч танаа

1. Хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоож хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах

Алтай сумын ИТХ-ын дарга М.Баатарсайхан танаа

1. Хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоож хэрэгжилтэнд хяналт тавин биелэлтийг 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Аймгийн Аудитын газарт ирүүлэх

Алтай сумын Засаг дарга Т.Баярцэцэг танаа

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан идэвхтэн байгаль хамгаалагчийг илрүүлсэн зөрчлийг харгалзан урамшуулал олгож цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх

ДҮГНЭЛТ

**УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ТҮҮНЭЭС ОРУУЛАХ ОРЛОГЫН
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР


Ирүүлсэн санал:


**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
82091 Харгат, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг,
Утас/Факс: (976) 7048-4042, E-mail: info@govi-altai.gov.mn

2016.10.05 № 6/1029
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн "Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлан, шийдвэрийн төсөлтэй танилцлаа. Тайлантай санал нэг байна. Холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.ЖАРГАЛСАЙХАН

02 01058